

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 11 дугаар сарын 15-ны өдөр

Сайншанд хот

| Д/д | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-----|--|---|--|---|
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх | 1.1. Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контетуудыг албан байгууллагын албан ёсны цахим хуудас: б/ сошиол сувгууд, в/ дотоод сүлжээ, г/ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/ бусад хэлбэрээр иргэд, олон нийтэд хүргэх; | -Тогтмол шинэчлэн тогтвортой байршуулсан байх, -Түгээсэн, хүрсэн үр дүнгийн талаар хариуцсан ажилтанд тухай бүр тайлагнадаг байх, Харьяа нэгжүүдийг нэгэн зэрэг хамруулж, үр дүнг нэгтгэн тайлагнаж хэвших | Авлигатай тэмцэх газраас бэлтгэсэн “Авлигын эсрэг нэгдье” шторк зурагт хуудсыг байгууллагын нэг цонхны үйлчилгээний хэсэгт байршуулсан дэлгэцээр тогтмол явуулан иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна. Соёмбо цогцолборын угтах хэсэг, үйлчилгээний заалны хананд “Авлигын эсрэг нэгдье” хуудсыг мэдээллийн самбарт байршуулж иргэд олон нийтэд хүргэн ажиллаж байна. |
| | | 1.2 Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, бүртгэлийн үйлчилгээг шуурхай хүргэх, иргэд олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах | Өдөрлөгт оролцсон иргэдээс байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт авч, түүнд үндэслэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байх, -Авилгатай тэмцэх газраас өрнүүлж буй аян, уриалгатай уялдсан байх | Авилгын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах зорилгоор мэдээллийн самбарыг тогтмол шинэчлэн ажиллаж байна. Мөн “Авилгын эсрэг хамтдаа” самбарт санал хүсэлтийн хайрцаг байрлуулан ажиллаж байна. Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх зорилгоор үйлчилгээний танхим болон Хяналтын улсын байцаагч, бичиг хэргийн ажилтны өрөөний үүдэнд болон архивын өрөөний гадна хаалганд “АВИЛГА АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ХАМТ ОЛОН” гэсэн сурталчилгааны хуудсыг наан байршуулсан. |

| | | | | |
|--|--|---|---|--|
| | | <p>1.3 Улсын бүртгэлийн байгууллагаас сар бүр эрхлэн гаргадаг цахим сэтгүүл болон бусад мэдээлэл, мэдээллийн хэсэгт авилгын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авилгын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчилах</p> | <p>Мэдээллийг Авилгатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх, Байгууллагын хэмжээний хүрээнд иргэд олон нийтрүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх, Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх</p> | <p>Хэлтсийн албан хаагчдын авилга хээл хахууль, хүнд сурталын талаар мэдээлэл хүлээн авах 7052-2200 утасны дугаарыг байршуулсан.</p> <p>Тус хэлтсийн цахим хуудаст байгууллагын үүсэл хөгжил, танилцуулга, бүтэц орон тооны талаарх мэдээлэл, удирдах албан тушаалтны танилцуулга, иргэдийг хүлээн авч уулзах албан тушаалтны өрөө, утасны дугаар зэргийг байршуулан тогтмол шинэчлэн ажиллаж байна.</p> <p>Улсын бүртгэлийн үйлчилгээ авах заавар, үнийн тарифийг цахим хуудаст байршуулсан. Мөн төлбөр төлөх киоск машинаар төлбөр төлөх боломжоор хангасан нь иргэд өөрт байгаа төлбөрийн хэрэгслээ ашиглан төлбөр төлөх нөхцөл бүрдсэн.</p> <p>Тус хэлтсийн дарга өдөр бүр ажлын цагаар иргэдийг хүлээн авч уулзан тэдний санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авахаас гадна үйлчилгээний танхимд өргөдөл, гомдлын хайрцаг, санал хүсэлтийн дэвтэр байршуулан, иргэдээс гаргаж буй санал хүсэлтийг мэдээллийн самбарт байршуулсан хэлтсийн даргын гар утас болон цахим хаягаар авах нөхцөлийг бүрдүүлсэн.</p> <p>Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах чиглэлээр нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах зарыг байгууллагын цахим хуудас болон фейсбүүк хуудсанд байршуулан алба хаагчдаар түгээлгэх ажлыг шуурхай зохион байгуулан ажилласан.</p> <p>“Хуульчдын Про-боно өдөр”-г үр дүнтэй зохион байгуулан ажиллаж иргэд, олон нийтэд ойр байдлаар зохион байгуулж, байгууллагын ил тод байдлын талаарх зурагт хуудсыг иргэд</p> |
|--|--|---|---|--|

| | | | | |
|---|--|---|---|--|
| | | | хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж зөвлөмж хүргүүлэх | |
| Зорилт 3. Авилга, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан , нөхцлийг арилгуулах арга хэмжээ авах | | | | |
| 3.1 | | Авилгын эрсдэл ба авилга гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах | Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах, -Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх -Хэрэгжилтийг тайлагнах | Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмж, шуурхай байдалд дүн шинжилгээ хийх зорилгоор тайлант хугацаанд 4 удаа 400 иргэнээс сэтгэл ханамжийн судалгаа авсан. Судалгаанд хамрагдсан иргэдээс 74 хувь нь хүссэн үйлчилгээгээ авч чадсан, 24 хувь нь зөвөлгөө, мэдээлэл авдаг, 2 хувь нь ачаалал ихтэй байна гэж хариулсан нь иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар сайжирч, албан хаагчийн харилцаа, хандлага мэргэшил, мэргэжлийн ур чадвар сайжирсныг харуулж байна. Мөн үйл ажиллагааны мэдээллийг нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 34 хувь нь вейб сайт, 26 хувь нь facebook буюу цахим хуудаснаас 27 хувь нь хамтран ажиллагсад, үлдсэн хувь нь мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, гэр бүл найз нөхдөөсөө авдаг гэсэн байна. |
| 3.2 | | Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдыг авилга, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх | -Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авилга, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авилгатай тэмцэх газарт шилжүүлж хэвших, -Албан хаагчдыг авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл | Тайлант хугацаанд АТГ-аас ирүүлсэн зөвлөмж, мэдэгдэл ирээгүй байна. Иргэдээс ажилтан, албан хаагчдад Авлигатай холбогдуулан гаргасан гомдол байхгүй байна. |

| | | | | |
|-----|--|---|--|---|
| | | | ажиллагааны онцлогт тохируулан эрсдлийг тодорхойлсон байх, Эрсдлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх | |
| 3.3 | | Авилгаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинэ санал санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх | Бүртгэлийн үйл ажиллагааг шуурхай хүртээмжтэй хүргэх ажлыг зохион байгуулж, арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх, Авилгатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх, Үйлчилгээ авдаг хамтарч ажилладаг зорилтот бүлэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн байх | Авлигын эсрэг үйл ажиллагааг сурталчлах, авлигын хор уршгийг алба хаагчдад таниулах зорилгоор тус хэлтсийн Иргэний улсын ахлах бүртгэгч Э.Уранбилэг "Мэдээллийн ил тод байдал", "Шүгэл үлээгчийг хамгаалах, хамтран ажиллах" зэрэг сэдвүүдээр сургалтыг зохион байгуулан ажилласан. Нийт алба хаагчдад Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт тусгагдсан заалтуудыг танилцуулан холбогдох мэдээллийг өгч ажилласан. |

ТАЙЛАН БИЧСЭН:
АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Н.ЦЭНДМАА

ТАЙЛАН ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТЭГШЖАРГАЛ

